



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/108

Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.5, 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2024 оны төсөв батлах тухай” 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтын 4.4.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говьсүмбэр аймгийн 30 жилийн ой, Төвийн бүсийн хурд, Боржигин наадмыг тэмдэглэхтэй холбоотой үзэгчдийн сандал түрээслэхэд шаардагдах 12,600,000 (арван хоёр сая зургаан зуун мянга) төгрөгийг аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн баяр наадмын зардлаас зарцуулахыг аймгийн ерөнхий санхүүч (Б.Соёлмаа)-д зөвшөөрсүгэй.

2. Хууль журмын дагуу гэрээ байгуулан ажиллаж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Содном) үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ

4212400260